



ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ТАЙЛАН
2023

Бидний тухай

- 4 Өмнөх үг
- 5 Бидний тухай
- 6 Тайлангийн цар хүрээ
- 7 2023 оны онцлох үзүүлэлтүүд

Тогтвортой хөгжлийн стратеги

- 9 Материаллаг байдал ба оролцогч талууд
- 10 Байгаль орчин, нийгэм, засаглалын стратеги
- 11 Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга зам

Байгаль орчин

- 13 Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах
- 15 Эрчим хүчний менежемент
- 19 Байгалийн нөөцийн зөв зохистой хэрэглээ
- 23 Биологийн олон янз байдал
- 24 Хог хаягдлын менежемент

Нийгэм

- 27 Олон янзат байдал ба хүртээмжтэй ажлын байр
- 31 Сайн дурын үйл ажиллагааг дэмжих
- 32 Сургалт, хөгжил, чадавхи бэхжүүлэх
- 33 Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй
- 34 Олон нийт, нийгэмд чиглэсэн арга хэмжээ

Засаглал

- 42 Засаглалын бүтэц
- 43 Эрсдэлийн менежмент
- 44 Тогтвортой нийлүүлэлтийн гинжин хэлхээ ба худалдан авалт
- 46 Эдийн засаг оруулж буй хувь нэмэр



A photograph showing the silhouettes of five business professionals in a meeting room. They are gathered around a glass wall covered with numerous colorful sticky notes. The room is dimly lit, with light coming from the background, creating a professional and collaborative atmosphere. The text 'Бидний тухай' is overlaid on the center of the image.

Бидний тухай »



» Өмнөх үг

М-Си-Эс Групп нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэж, тогтвортой хөгжлийн зорилгыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж, энэхүү үнэт зүйлийнхээ хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) тогтолцоог бүрдүүлж ирлээ.

БОНЗ-ын болон тогтвортой хөгжлийн чиг хандлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, урт хугацаандаа “Net-Zero” компани болох зорилтдоо хүрэхээр хэрэгжүүлж эхлээд буй бидний ажлын үр дүн, хүрсэн амжилтуудаа хэмжин үнэлж, Монгол Улсын “Алсын хараа – 2050” болон бусад урт хугацааны бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд оруулж буй хувь нэмрээ энэхүү Тогтвортой хөгжлийн тайлангаараа дамжуулан хүргэхээр зорьдог билээ.

Бид байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөө тооцох, цаашлаад хүлэмжийн хийн ялгарлыг үе шаттайгаар бууруулах арга хэмжээг чухалчилж, олон улсын стандарт, арга зүйн хүрээнд зургаан компанидаа хүлэмжийн хийн ялгарлыг 2021 оноос тооцож эхэлсэн. Улмаар эхний ээлжид хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг бизнесийн салбарууддаа нэгдсэн зорилтоо тодорхойлж, 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 22.7 хувиар бууруулах Монгол Улсын зорилтод өөрсдийн хувь нэмрийг оруулж байна.

Түүнчлэн хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах, дахин ашиглах санаачилгыг тайлант онд өргөжүүлж, хуванцрын хаягдлаас гадна хөнгөн цагаан, электрон хог хаягдлыг дахин боловсруулж эхэллээ.

Тухайлбал Юнивишн компани үйлчилгээний хуучирсан төхөөрөмжийг хэрэглэгчдээс цуглуулан авч, дахин боловсруулалтад оруулснаар бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг үр дүнтэй удирдаж, тойрог эдийн засгийг бүрдүүлэх нэгэн чухал алхам болсон юм.

М-Си-Эс Группийн 30 жилийн түүхэн ой тохиосон 2023 онд бид өнгөрсөн ололт амжилт, улс, эх орныхоо хөгжил дэвшилд оруулсан бүтээн байгуулалтуудаа нийт ажилтныхаа хамтаар тэмдэглэлээ. Бид тайлант онд ажилтнууддаа чиглэсэн бодлогын хүрээнд ажилтанд зориулсан хөнгөлөлттэй бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг дороос авах MCS Benefits платформыг нэвтрүүлж, ажилтнууддаа бодитой дэмжлэг үзүүлж байна.

М-Си-Эс Групп өнгөрсөн 30 жилийн хугацаанд олон улсын жишигт нийцсэн компанийн засаглал, нийгмийн хариуцлагын хэм хэмжээг баримталж ирсэн. Харин ирэх 30 жилийн зорилтоо бид тогтвортой хөгжлийн зорилго, БОНЗ-ын тогтолцоог бүрдүүлсэн “Net-Zero” компани болохоор зорьж байна. Тогтвортой ирээдүйг бий болгох урт хугацааны зорилго, зорилтдоо хүрэхээр хэрэгжүүлж буй бидний ахиц, дэвшил болон амжилтуудаа энэхүү тайлангаараа бид хүргэж байна.



» Бидний тухай

Эрчим хүчний зөвлөгөө өгөх чиглэлээр 1993 онд үүсгэн байгуулагдсан М-Си-Эс Групп нь эрчим хүч, дэд бүтэц, инженеринг, мэдээлэл, харилцаа холбоо, барилга, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, хөдөө аж ахуй, банк санхүү, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, эрүүл мэнд зэрэг салбарт үйл ажиллагаа эрхэлж, татвар шимтгэл, хөрөнгө оруулалт, ажлын байр зэрэг үзүүлэлтээр улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж, тогтсон байгууллагын соёлтой, төлөвшсөн боловсон хүчинтэй, түүчээлэх чадвартай үндэсний хэмжээний Групп компани болон тэлжээ.

Бид нийгэм, улс орон, эх дэлхийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, дэлхийн шилдэг стандарт, дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлж, олон улсын хөрөнгө оруулагчид болон түншүүдтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлж, байгаль орчин, нийгэм, засаглалын тогтолцоог нэвтрүүлэн, урт хугацаанд тогтвортой хөгжлийн зорилгуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.



» Тайлангийн цар хүрээ

М-Си-Эс Групп нь үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийн салбарууддаа тогтвортой хөгжлийн зорилгуудыг урьтал болгон ажилладаг. Үүний хүрээнд бид өөрсдийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн арга хэмжээ болон, байгаль орчиндоо ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг энэхүү Тогтвортой хөгжлийн тайлангаараа дамжуулан хүргэхээр зорьж байна.

Ёс зүйтэй, нээлттэй засаглалыг бүрдүүлэх нь бидний байгаль орчин, нийгэм, засаглалын стратегийн гол цөм билээ. Тийм ч учраас олон нийт болон оролцогч талууддаа үнэ цэнийг алхам тутамдаа бүрдүүлэхээр зорьж, үйл ажиллагааны нөлөөллөө хэрхэн харгалзан авч үзэж буй талаар зэрэг БОНЗ-ын хүрээнд хэрэгжүүлж буй

олон арга хэмжээний тодорхой хэсгийг энэхүү тайланд жишээ болгон нийтэлдэг.

Түүнчлэн тогтвортой хөгжлийн стратеги, хэрэгжүүлсэн ажлуудын гол үр дүн, тулгарч буй асуудал зэрэг тогтвортой хөгжилд нийцсэн олон талт арга хэмжээг бүх оролцогч талууддаа хүргэхээр зорилоо.

Бид энэхүү Тогтвортой хөгжлийн нэгтгэсэн тайландаа үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийн салбарын харилцан адилгүй, ялгаатай байдлыг харгалзан үзэж, “Тайлагналын олон улсын санаачилга (GRI)”, “Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)” болон бусад холбогдох тайлагналын стандартын ерөнхий бүтэц, гол агуулга, хэмжигдэхүүнд суурилж бэлтгэсэн.





» 2023 оны онцлох үзүүлэлтүүд

Байгаль орчин

1,226 мян тонн

CO₂-эков. хүлэмжийн хийг түвшин 1 ба 2-ын хүрээнд ялгаруулсан

3,899 МВт.ц

эрчим хүчийг сэргээгдэх эх үүсвэрээр цахилгаан үйлдвэрлэсэн



6,641 тонн

CO₂-эков. хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан

1.2 сая тонн

усыг дахин ашигласан



1,100 МВт.ц

эрчим хүчний хэмнэлтийг бий болгосон



461 тонн

үйл ажиллагааны хүрээнд үүссэн хог хаягдлыг дахин боловсруулсан

Нийгэм

13 мянган

ажилтантай



115 мянган

ажилтан ХАБЭА сургалт, зааварчилгаанд хамрагдсан



39%

нийт эмэгтэй ажилтан

14.3 мянган

ажилтан сургалтад хамрагдсан



51%

эмэгтэй менежер

4.3

Ажилтны сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ



41%

эмэгтэй гүйцэтгэх удирдлага

Эдийн засаг

966 тэрбум

төгрөгийн татвар, шимтгэлийг төлсөн



987 тэрбум

төгрөгийн хөрөнгө оруулалт Монгол Улсын эдийн засагт хийсэн



3.5 их наяд

төгрөгийн худалдан авалт хийсэн

2.2 их наяд

төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг дотоодын 8,600 компани болон хувь хүнээс худалдан авсан

50 тэрбум

төгрөгийг нийгмийн хариуцлагын 45 төсөл, хөтөлбөрт зарцуулсан

20,000+

шууд бус ажлын байрыг бий болгож байна



A large solar farm with rows of solar panels in a snowy field at sunset. The sky is a mix of blue and orange, and the ground is covered in snow. The solar panels are tilted and arranged in long, parallel rows.

Тогтвортой хөгжлийн стратеги ▶



» Материаллаг байдал ба оролцогч талууд

Оролцогч талууд →

- ✓ Хувьцаа эзэмшигчид
- ✓ Хөрөнгө оруулагчид
- ✓ Ажилтнууд
- ✓ Нийлүүлэгчид
- ✓ Туслан гүйцэтгэгчид
- ✓ Хэрэглэгчид
- ✓ Төрийн ба Төрийн бус байгууллага
- ✓ Олон нийт

БОНЗ-ын асуудлууд →

Байгаль орчин

- ✓ Цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг дэмжих
- ✓ Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг бий болгох
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах
- ✓ Нөөцийн зохистой хэрэглээ, сөрөг нөлөөллийг бууруулах
- ✓ Хог хаягдлын менежмент
- ✓ Биологийн олон янз байдлыг хамгаалах

Нийгэм

- ✓ Эрүүл, аюулгүй ажиллах орчин
- ✓ Ажилтны хүсэл, шаардлагад тулгуурласан хүний нөөцийн бодлого
- ✓ Ажилтны сурч, хөгжих боломж
- ✓ Олон янзат байдал, хүртээмжтэй байдлыг бий болгох
- ✓ Ажлын байрны ёс зүй, эрх тэгш байдлыг хангах
- ✓ Хүний эрхийг дээдлэх
- ✓ Нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулах
- ✓ Орон нутгийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа, туслалцаа дэмжлэг

Засаглал

- ✓ Ил тод, нээлттэй засаглалтай байх
- ✓ Ёс зүйтэй, шударга бизнес
- ✓ Хууль, дүрэм журамд нийцсэн
- ✓ БОНЗ-ын нээлттэй тайлагнал
- ✓ Дижитал, цахим шилжилт
- ✓ Тогтвортой нийлүүлэлтийн гинжин хэлхээг хөгжүүлэх

БОНЗ-ын стратеги →



Байгаль орчин

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах



Нийгэм

Эрүүл, аюулгүй, хүртээмжтэй ажиллах орчныг бүрдүүлж, нийгэмдээ хувь нэмэр оруулах



Засаглал

Бизнесийн ёс зүйтэй, ил тод, нээлттэй, хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэх



» Байгаль орчин, нийгэм, засаглалын стратеги

М-Си-Эс Групп байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тогтолцоог үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийн салбарын онцлогт тохируулан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, нийгэмдээ ээлтэй, хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэхийг эрхэмлэн, урт хугацаандаа тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн, ил тод, хариуцлагатай засаглалыг бүрдүүлэхээр БОНЗ-ын стратегиа тодорхойлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээр зорьдог.

БОНЗ-ын стратеги

 Байгаль орчин	 Нийгэм	 Засаглал
Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмрээ оруулах	Эрүүл, аюулгүй ажиллах орчныг бүрдүүлэх	Ёс зүйтэй, хараат бус менежментийн арга барил бүхий зөв засаглалыг хөгжүүлэх
Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, зохистой хэрэглээг дэмжих	Хөдөлмөрийн зохистой, үр ашигтай харилцаа эрхэмлэх	Хууль, дүрэм, журамд нийцсэн үйл ажиллагаа эрхлэх
Байгалийн нөөцийн зөв, зохистой хэрэглээ, биологийн олон янз байдлыг хамгаалах	Жендерийн эрх тэгш, олон янзат, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх	Үнэн зөв, ил тод тайлагналын тогтолцоо бэхжүүлэх
Хог хаягдлын менежмент, хэрэглээг бууруулах	Нийгэмдээ хувь нэмрээ оруулах, оролцогч талуудтай харилцах	Тогтвортой, хариуцлагатай нийлүүлэлтийн гинжин хэлхээг дэмжих



» Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга зам

М-Си-Эс Групп нь өөрсдийн үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг үе шаттайгаар бууруулахыг чухалчилж байна. Энэ хүрээнд үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлаа олон улсын стандарт, арга зүйн дагуу тооцож эхэлсэн билээ.

Ингэснээр урт хугацаандаа хүлэмжийн хийн ялгарлыг шат дараатай бууруулах бидний суурь алхам болсон юм.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад дараах чиглэлүүдэд голчлон анхаарна:



Эрчим хүчний үр ашигтай хэрэглээ

- ✓ Дэвшилтэт техник, технологи ашиглах
- ✓ Бага нүүрстөрөгч бүхий хэрэглээнд шилжих



Сэргээгдэх эрчим хүч

- ✓ Цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг хэрэглээндээ нэвтрүүлэх
- ✓ Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдэд хөрөнгө оруулах



Малтмал түлшний хэрэглээг бууруулах

- ✓ Байгальд ээлтэй бусад эх үүсвэрт шилжих
- ✓ Түлшний хэмнэлтийг нэмэгдүүлэх



Үйл ажиллагаа, үйлдвэрлэлийг оновчлох

- ✓ Үйлдвэрлэлийн бүхий л явцад хүлэмжийн хийг хянах
- ✓ Шууд бус хүлэмжийн хийн ялгарлыг хянах
- ✓ Нийлүүлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх ялгарлыг хянах



Байгаль орчин »



» Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

● Хүлэмжийн хийн ялгарал

М-Си-Эс Группийн зарим компани түвшин 1 ба 2-ын хүрээнд хүлэмжийн хийн ялгарлаа тооцож, цаашид хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ялгаруулахаас зайлсхийх арга хэмжээг авахаар зорин ажиллаж байна.

Тайлант онд М-Си-Эс Группийн өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, харилцаа холбоо болон уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд хүлэмжийн хийн ялгарлаа тооцсон юм.

Салбар	Түвшин 1	Түвшин 2
Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний салбар	18.9	6.8
Харилцаа холбооны салбар	0.7	13.8
Уул уурхайн салбар*	1,168.5	16.8
	мянган тонн CO ₂ -экв.	мянган тонн CO ₂ -экв.

*Энержи Ресурс компани 2023 оноос хүлэмжийн хийн ялгарлаа тооцох аргад өөрчлөлт оруулж, хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг болсон.

Хүлэмжийн хийн ялгарлын түвшин

Түвшин 1 (шууд ялгарал)

Үйл ажиллагааны явцад ялгарах хүлэмжийн хий

Түвшин 2 (шууд бус ялгарал)

Худалдан авч буй цахилгаан ба дулаанаас үүсэх шууд бус ялгарах хүлэмжийн хий



» Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах

- Хүлэмжийн хийн ялгарлын бууралт

4,800 тонн CO₂-ЭКВ.

хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан:

М-Си-Эс Кока-Кола компани Монгол – Япон Улсын Засгийн газар хоорондын “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл”-ийн хүрээнд, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор нүүрсээр ажилладаг зуухыг халж, шингэрүүлсэн түлшээр ажилладаг агаарын бохирдол үүсгэдэггүй дэвшилтэт уурын зуухыг М-Си-Эс Интернэйшнл компанитай хамтран үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.



1,841 тонн CO₂-ЭКВ.

хүлэмжийн хийг агаар мандалд ялгаруулахаас зайлсхийсэн:

1,281 тонн CO₂-ЭКВ.

Юнител Групп болон Эрчим Сүлжээ компаниуд нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашигласан.

361 тонн CO₂-ЭКВ.

М-Си-Эс Кока-Кола, Юнител Групп, Энержи Ресурс, М-Си-Эс Интернэйшнл, Интермед эмнэлэг, Шангри-Ла Улаанбаатар компаниуд эрчим хүчний хэмнэлтийг бий болгосон.

2 тонн CO₂-ЭКВ.

Эрчим Сүлжээ компани цахилгаан автомашиныг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

197 тонн CO₂-ЭКВ.

Эрчим Сүлжээ компани гүйдлийн трансформаторын коэффициент, хүчний трансформаторын чадлыг бодит ачаалалд тохируулан шинэчилсэн.





» Эрчим хүчний менежмент

● Эрчим хүчний хэмнэлт

М-Си-Эс Кока-Кола, Юнител Групп, Энержи Ресурс, М-Си-Эс Интернэйшнл, Интермед эмнэлэг, Шангри-Ла Улаанбаатар компаниуд эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хувьд эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг гарган тайлагнаж, бууруулах арга хэмжээг авч ажилладаг.

Мөн Эрчим Сүлжээ компани дэд станцууддаа алдагдал бууруулах техникийн тохируулгын тооцоог хийсэн ба гүйдлийн трансформаторын коэффициент, хүчний трансформаторын чадлыг бодит ачаалалд тохируулан шинэчлэх ажлуудыг хэрэгжүүлснээр эрчим хүчний хэмнэлтийг бий болгож байна.

▶ 2023 онд эрчим хүчний үр ашигтай ашиглалтыг дэмжих төлөвлөгөөний дагуу нийт 1,100 МВт.ц эрчим хүч хэмнэлээ.

5 МВт.ц	М-Си-Эс Кока-Кола	38 МВт.ц	Интермед
65 МВт.ц	Юнител	172 МВт.ц	Шангри-Ла Улаанбаатар
133 МВт.ц	Энержи Ресурс	600 МВт.ц	Эрчим Сүлжээ
86 МВт.ц	М-Си-Эс Интернэйшнл	 <div style="border: 2px solid green; padding: 10px; display: inline-block;"> 1,100 МВт.ц </div>	





» Эрчим хүчний менежмент

- Цэвэр эрчим хүчний эх үүсвэр



3,899 МВт.ц

Тайлант онд Юнител Групп болон Эрчим Сүлжээ компаниуд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр нийт 3,899 МВт.ц үйлдвэрлэн ашигласан ба цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр шилжилтийг шат дараатай эхлүүлж байна.

Юнител Группийн хувьд 2022 оноос хойш нарны эрчим хүчээр ажилладаг нийт 216 суурин станцыг байгуулсан. 2023 онд тус компани нийт 3,897.5 МВт.ц эрчим хүчийг цэвэр эх үүсвэрээр үйлдвэрлэсэн ба нийт цахилгаан хэрэглээний найман хувийг сэргээгдэх эх үүсвэрээр хангажээ.



М-Си-Эс Кока-Кола компани шингэрүүлсэн хийн түлшээр ажилладаг зуух ашиглан тайлант онд нийт 67.5 сая МЖ дулаан болон технологийн уурыг үйлдвэрлэн ашигласан байна.





» Эрчим хүчний менежмент

• Эрчим хүчний үр ашигтай хэрэглээ

Эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хувьд М-Си-Эс Кока-Кола, М-Си-Эс Интернэйшнл компани болон Интермед эмнэлэг нь эрчим хүчний хэмнэлтийг бий болгохоос гадна үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэхээр нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулж буй эрчим хүчний хэрэглээг тогтмол хянадаг.

19.98 КВт.ц

М-Си-Эс Кока-Кола компани 1л бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг 19.98 КВт.ц болгон өмнөх жилтэй харьцуулахад 8.5 хувиар бууруулсан.

9.67 КВт.ц

М-Си-Эс Интернэйшнл компани нэгж цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд зарцуулах эрчим хүчний зарцуулалтыг 9.67 КВт.ц болгон өмнөх жилтэй харьцуулахад 0.16 хувиар бууруулжээ.

28.57 КВт.ц

Интермед эмнэлэг нэгж бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулах эрчим хүчний зарцуулалтыг 28.57 КВт.ц болгон өмнөх жилтэй харьцуулахад 3.8 хувиар бууруулсан байна.





» Эрчим хүчний менежмент

▶ Түлшний хэмнэлт

Тотал Дистрибушин компани түлшний шаталтаас үүсэх хийн ялгарлыг бууруулж, түлшний хэмнэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Евро-5 шатахуунд шилжиж байна.



▶ Цахилгаан тээврийн хэрэгслийн дэд бүтэц

Эрчим Сүлжээ компани цахилгаан тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэхээр цэнэглэгч станцын дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэх “EV+” төслийг хэрэгжүүлж, тайлант онд нийслэлийн таван байршилд есөн цэнэглэгч станцыг байгуулснаас гадна албаны хэрэгцээндээ цахилгаан автомашиныг ашиглаж эхлээд байгаа юм.

Төслийг хэрэгжүүлснээр нүүрсхүчлийн хийн ялгарал багатай хэрэглээг дэмжихээс гадна хөдөлгүүрийн дотоод шаталтаас үүдэлтэй агаар бохирдуулагч хийг ялгаруулахаас зайлсхийх зэрэг олон талын давхар үр ашигтай.





» Байгалийн нөөцийн зөв зохистой хэрэглээ

● Усны хэрэглээ ба менежмент

М-Си-Эс Группийн хэмжээнд Энержи Ресурс, М-Си-Эс Кока-Кола, М-Си-Эс Интернэйшнл компаниуд үйлдвэрийн болон ахуйн хэрэглээнд зориулан ус цэвэршүүлэхээс гадна, хэрэглэсэн хаягдал усыг цэвэршүүлэх байгууламжаар боловсруулдаг.

Говийн уур амьсгалд тохирсон, хуурай хөргөлтийн систем бүхий Ухаа Худагийн цахилгаан станц нь бусад дулааны цахилгаан станцтай харьцуулахад хоёр дахин бага ус зарцуулдаг ба М-Си-Эс Интернэйшнл компани нь тайлант онд 13,371 тонн усыг эсрэг осмосын төхөөрөмжөөр цэвэршүүлж, цахилгаан станцад дахин ашигласан байна. Түүнчлэн химийн хяналтын лабораторийн шинжилгээгээр MNS 4943:2018 стандартын шаардлага хангасан

үйлдвэрийн хаягдал усны 26 хувийг зам усалгаанд болон бусад дотоод хэрэгцээнд дахин ашиглаж байна.

М-Си-Эс Кока-Кола компани үйлдвэрийн хаягдал ус цэвэршүүлэх үйлдвэрийг 2010 онд ашиглалтад оруулсан ба жилд 180 мянган тонн усыг MNS 4943:2015 болон MNS 6734:2018 стандартын дагуу 99.9 хувь цэвэршүүлж боловсруулдаг. Энэхүү цэвэршүүлсэн саарал усыг ногоон байгууламжийн усалгаа, ойжуулалт, хот тохижилт болон автомашин угаалга зэрэг олон талаар ашиглах боломжтой ба хэрэглэх хүсэлтэй аж ахуйн нэгж, хэрэглэгчдэд үнэ төлбөргүй өгдөг бөгөөд тайлант онд нийт цэвэршүүлсэн усны тав орчим хувийг дахин ашиглажээ.





» Байгалийн нөөцийн зөв зохистой хэрэглээ

● Усны хэрэглээ ба менежмент

Энержи Ресурс компанийн нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэдэх Хаягдал усгүйжүүлэх үйлдвэр нь хаягдлын лагийг шахаж, усыг нь шавхсанаар усныхаа 95 хүртэлх хувийг дахин ашигладаг ба тайлант онд 1,145,000 м³ усыг дахин ашиглажээ. Түүнчлэн гадаргын ус цуглуулах цөөрөмд 81,000 м³ усыг цуглуулж, үйлдвэрийн болон бусад хэрэгцээнд дахин ашигласан бол 180,699 м³ ахуйн бохир усыг цэвэршүүлснээс 7 мянган тонныг мод услах болон уурхайн тоос дарах зэрэгт ашигласан байна.

1,145,000м³

Энержи Ресурс компанийн дахин ашигласан усны хэмжээ

4%

М-Си-Эс Проперти компани барилга угсралтын ажлын үеэр гарсан хаягдал усны дөрвөн хувийг зам усалгаанд дахин ашиглажээ.

49%

Топ Моторс компани авто угаалгад ашигласан усны 49 хувийг цэвэршүүлэн дахин ашиглаж байна.



▶ Усны үр ашигтай хэрэглээ

М-Си-Эс Кока-Кола компани 2023 онд нэг литр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 2.19 литр ус ашигласан бөгөөд сүүлийн 10 жилийн хугацаанд 17 хувиар бууруулаад байна.

Энержи Ресурс компанийн хувьд олборлолт, баяжуулалтын хэмжээнээс шалтгаалан усны ашиглалт, дахин ашиглалтын хэмжээ харилцан адилгүй байдаг ба баяжуулалтын нэг тонн тутамд ашигласан усны хэмжээ тайлант онд 207 литр байсан.



» Байгалийн нөөцийн зөв зохистой хэрэглээ

● Ойжуулалт

2023 он

67 мянган мод

Навчит модны тарьц, суулгац бэлтгэх, тариалангийн талбайд хамгаалалтын зурвас байгуулж, хөрсний элэгдлийг бууруулах зорилготойгоор Энержи Ресурс компани Мэтагро компанитай хамтран ажиллаж байна. Үүний хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт 18 км урт ойн зурваст зориулан Энержи Ресурс компани 17 мянган улиас болон хайлаас мод тарьсан.

Түүнчлэн Энержи Ресурс компани Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутагт Заган ойжуулалт хийх зорилгоор 10 мянган заг мод тарьсан байна.

Өнгөрсөн онд М-Си-Эс Группийн ажилтнууд Богдхан уулын Хүрхрээгийн аманд байрлах 1 га газарт 3,000 мод, бусад байршилд 5,900 мод тарьсан.





» Байгалийн нөөцийн зөв зохистой хэрэглээ

● Ойжуулалт

▶ Тарьц, суулгацын нөөц бүрдүүлэлт


Энержи Ресурс компани Цогтцэций суманд байрлах мод үржүүлгийн 2.5 га талбайдаа Говийн нөхцөлд тохирсон олон төрлийн үр, суулгацыг бэлтгэдэг ба 26 өөр төрөл, зүйлийн 30 мянган ургамлыг бойжуулдаг. 2023 онд энэхүү талбайдаа таван төрлийн 1,100 мод, сөөгийг мөчир болон үрээр тарин бойжуулж байна.

Түүнчлэн Мэтагро компани мод бэлтгэн үржүүлэх хүлэмж, талбайг байгуулж, 2023 оны туршид 34 мянга гаруй суулгацыг хүлэмжид, долоон мянга гаруй суулгацыг үржүүлгийн талбайдаа бэлтгэсэн ба цаашид төрөл зүйл болон хүчин чадлыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.



▶ Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

2023 онд Энержи Ресурс компани Цогтцэций сумын нутагт орон сууц, олон нийтийн гудамж талбай болон ажилтны кэмпийн орчны тохижилтод зориулан 29 мянган мод, Баруун Наран уурхайн кэмпийн орчны тохижилтод зориулан 2,500 мод тарьсан бол М-Си-Эс Интернэйшнл компани Ухаа Худагийн цахилгаан станцын бүсэд 888 мод тарьжээ. Харин Мэтагро компани Хэнтий аймагт байрлах ажилтны кэмпийн тохижилтод зориулан 125 мод тарьжээ.



Түүнчлэн М-Си-Эс Групп “Өв Эрдэнэ” соёлын өвийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Хэнтий аймгийн Чингис хотын төвд байрлах Сэцэн ханы ордны 3,000 м² гадна талбайд зүлэгжүүлэлт, ногоон байгууламжийн тохижилтын ажлыг 2023 онд хийж гүйцэтгэсэнээс гадна, Улаанбаатар хотын төвд байрлах Чойжин ламын сум музейн зүлэг, ногоон байгууламжийн арчилгаа, үйлчилгээг дэмжин ажилласан юм.



» Биологийн олон янз байдал

Юнител Групп, Энержи Ресурс, Мэтагро, Эрчим Сүлжээ компаниуд байгаль орчинд учруулж болзошгүй нөлөөллийг үнэлж, менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг. Үүний хүрээнд сөрөг нөлөөгүй байж, үүсэж болзошгүй эрсдэл, хохирлыг бууруулах шаардлагатай арга хэмжээг авч, өртөж болзошгүй биологийн төрөл зүйлийн судалгаа, мониторингийг хийн хамгааллын менежментийг хэрэгжүүлэх, дүйцүүлэн хамгаалах зэрэг арга хэмжээг авч, нэгдсэн менежментийн төлөвлөгөөний дагуу хөтөлбөр болгон хэрэгжүүлж байна

Энержи Ресурс компани Цогтцэций сумын нутагт байрлах ойн зурваст болон Тавантолгой нисэх буудлын орчимд шувуудын судалгааг байгаль орчны мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. Судалгааг арга зүйн дагуу гурван харууц цэгийг сонгож хийсэн ба шугаман замналын дагуу явж бүртгэл хөтлөхөд 44 байршлаас 21 зүйлийн 200 бодгалийг бүртгэсэн. Судалгааны үр дүнд шувууны гурван төрөл, зүйл шинээр бүртгэгдсэн бол шувууны тоо толгой 653-аар цөөрсөн үзүүлэлттэй гарсан байна.



Эрчим Сүлжээ компани шувууд цахилгаан дамжуулах агаарын шугамын өндөр хүчдэлд цохиулах эрсдэлээс сэргийлэх зорилгоор ажиглалт хийсний үр дүнд 50 шувуу үргээгчийг байрлуулжээ. Ингэснээр тэдгээрийн амьдрах орчин, нүүдэл, үржилд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, агаарын шугам дамжин өнгөрч буй бүс нутагт амьдардаг шувууны төрөл зүйлийг хамгаалж, эрсдэлийг багасгаж байна.



Юнител Групп тусгай хамгаалалт бүхий алслагдсан, усны нөөц хомс газруудад зэрлэг амьтдад зориулсан хөв, цөөрөм байгуулах ажлыг эхлүүлсэн ба 2023 онд 10 тусгай хамгаалалттай газарт, 16 хөв цөөрмийг барьж байгуулснаар нийт 23 хөв цөөрмийг барьж, цоохор ирвэс, мазаалай, янгир зэрэг улаан номд орсон ховордсон болон бусад тухайн бүс нутагт оршин суух амьтдын ундны усны хэрэгцээг хангахад хувь нэмрээ оруулж байна.





» Хог хаягдлын менежмент

- Бид үйл ажиллагаанаас үүсэх энгийн болон аюултай хог хаягдлыг зориулалтын дагуу боловсруулж, зохих арга хэмжээг авдаг. 2023 онд:

▶ 461 тонн

оффисын болон бусад хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгсөн.

▶ 317 тонн

аюултай хог хаягдлыг зохих журмын хүрээнд зориулалтын дагуу устгасан.

Дэд станцуудын тогтмол тэжээлийн батарей болон ашигласан тос зэрэг 4 орчим тонн хог хаягдлыг зориулалтын дагуу хадгалж байна.

▶ 1,146 тонн

энгийн хог хаягдалд зохих арга хэмжээг авсан.



- ▶ Мэтагро компани **2.3 тонн** хүнсний болон био-органик хаягдлыг дахин боловсруулж, ялзмаг болгон хувиргаж, газар тариалангийн хэрэглээнд дахин ашиглажээ.

- ▶ М-Си-Эс Кока-Кола компани 2014 оноос эхлэн бүтээгдэхүүний сав, баглаа, боодлын жинг бууруулж буй бөгөөд тайлант онд **48 тонн** хуванцрын хэмнэлтийг бий болгожээ.



» Хог хаягдлын менежмент

• Хаягдал цуглуулах, дахин боловсруулах, ашиглах санаачилга

▶ Хуванцрын хаягдалгүй дэлхий

М-Си-Эс Кока-Кола компани “Хуванцрын хаягдалгүй дэлхий” кампанит ажлын хүрээнд хуванцрын хаягдал хүлээн авах цэгийг Улаанбаатар хот болон орон нутгийн 16 аймагт байгуулсан.

2023 онд Тотал Дистрибушин компани орон нутгаас 24 тонн хуванцрын хаягдлыг цуглуулан Улаанбаатар хот руу тээвэрлэхэд хамтран ажилласан бөгөөд М-Си-Эс Кока-Кола компани нийт борлуулсан ПЭТ хуванцар савны 40 хувийг буцаан цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгсөн.



▶ No E-Waste

Юнител Групп Юнивишн үйлчилгээний хуучирч, ашиглалтаас гарсан Zuxel төхөөрөмжийн цахим хаягдлыг салбарт эргүүлэн авах болон дуудлагын үйлчилгээний ажилтнуудад ашиглалтын хугацаа дууссан төхөөрөмжөө өгч явуулах байдлаар цуглуулах “No E-waste” кампанит ажлыг тайлант онд эхлүүлэн 17 мянган хуучин төхөөрөмжийн 3.7 тонн хаягдлыг цуглуулжээ.

Эдгээр төхөөрөмжийг эх хавтан болон гаднах хатуу хуванцраар нь ангилж, боловсруулан эх хавтанг дахин ашиглахаар цуглуулж байгаа бол гаднах хатуу хуванцрыг боловсруулалтад илгээж, улмаар М-Си-Эс Проперти компанийн барилгын төсөлд арматурын ивүүр болгон ашиглаж байна.

▶ Go Recycle

Вэллбий компани өөрсдийн борлуулж буй бүтээгдэхүүний хуванцар болон хөнгөн цагаан савыг хэрэглэгч, харилцагч байгууллагуудаасаа эргүүлэн авах аяныг эхлүүлэн дахин боловсруулах боломжтой сав цуглуулах хайрцгийг 40 байршилд байрлуулсан. Өнгөрсөн онд аяны хүрээнд 260 кг хөнгөн цагаан хаягдал, 40 кг HDPE, LDPE, PP хуванцар савлагааг эргүүлэн цуглуулж, дахин боловсруулаад байна.



Нийгэм ▶



» Олон янзат байдал ба хүртээмжтэй ажлын байр

- Ажиллах орчин ба ажилтнууд:

12,906 Үндсэн ажилтан	570 Гэрээт ажилтан	20,000+ Шууд бусаар бий болгож буй ажлын байр
825 Менежер	210 Гүйцэтгэх удирдлага	372 Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан

- ▶ Хүйсийн тэнцвэрт байдал



39% - Эмэгтэй ажилтан
51% - Эмэгтэй менежер
41% - Эмэгтэй гүйцэтгэх удирдлага

Ажилтны сэтгэл ханамж **4.3**

Бид ажилтны сэтгэл ханамжийн судалгааг нийт ажилтны дунд жил бүр зохион байгуулдаг ба сэтгэл ханамжийн үнэлгээг 14 үзүүлэлтээр тодорхойлж, жигнэсэн дунджийг гаргадаг.

Ажилтны оролцоо **4.4**

Ажилтны оролцоо буюу компанийн үнэт зүйлийн төлөөх ажилтны хандлага, үйлдэл, итгэл үнэмшлийн түвшнийг найман үзүүлэлтээр тодорхойлон жигнэсэн дунджийг тооцдог.

- ▶ Хүртээмжтэй ажлын байр ба ажилтны оролцоо

Бид ажилтнууддаа хүртээмжтэй, уян хатан ажиллах орчныг санал болгохоос гадна ажилтны шинэ санал, санаачилгыг дэмжиж, ажилтан бүртээ хийж буй ажил, ажиллаж буй компанидаа сэтгэл ханамжтай, харилцан итгэлцэл, эерэг дулаан найрсаг баг хамт олон бүхий байгууллагын соёлыг бүрдүүлэн ажиллахыг чухалчилдаг.





» Олон янзат байдал ба хүртээмжтэй ажлын байр

● Ажилтны хөнгөлөлт, хангамж

Бид ажилтнууддаа ажлаа сэтгэл ханамжтай гүйцэтгэх боломжийг бий болгох зорилгоор нийгмийн асуудал болон эрүүл мэндэд нь дэмжлэг үзүүлэн, хувь хүний хөгжилд нь тогтмол анхаарч, хамтдаа хөгжих орчныг бүрдүүлэхийг зорьдог.

2023 онд

12.4 тэрбум

төгрөгийн хөнгөлөлт, хангамжийг ажилтнууддаа олгосон.

▶ М-Си-Эс Группийн хөнгөлөлт, хангамж



Хурим, хүүхдийн баяр, шинэ төрсөн хүүхэд, ахмад настны бэлэг



Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг



Үйл ажиллагааны онцлогоос шалтгаалсан ажилтанд зориулсан даатгал, хөнгөлөлттэй эрүүл мэндийн даатгалд өөрийгөө болон гэр бүлээ хамруулах боломж



Ажлын байрны зэрэг, онцлогоос хамаарсан хоолны хөнгөлөлт, Группийн охин болон хараат компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд болон бусад чиглэлийн 40 орчим байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөнгөлөлт



Өндөр насны нэг удаагийн тэтгэмж



Хамтран ажиллагч банкуудаас хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авах боломжууд



Төрсөн өдрийн, шинэ хүүхэдтэй болоход өгөх цалинтай чөлөө, нийгэм, байгаль орчинд тустай сайн дурын үйлсэд оролцоход өгөх цалинтай чөлөө г.м



М-Си-Эс Академи, гадаад, дотоодын мэргэжлийн сургалтуудад хамрагдах боломж

▶ MCS Benefits платформ

Бид ажилтнууддаа хөнгөлөлт, хангамжийн багц журмын хүрээнд эдлэх боломжтой бүхий л мэдээллийг нэг дороос авч, М-Си-Эс Группийн компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “MCS Benefits” платформыг 2023 онд шинээр нэвтрүүлсэн.

Түүнчлэн “MCS Benefits” платформуос хөнгөлөлттэй үнээр бараа, үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлж, дэмжих зорилгоор ажилтны үндсэн цалин дээр нэмэлт мөнгөн урамшууллыг тогтмол олгож эхэлсэн ба тайлант онд нийт 11 тэрбум төгрөгийг нэмэлт урамшуулал байдлаар ажилтнуудад олголоо.



» Олон янзат байдал ба хүртээмжтэй ажлын байр

● Ажилтны эрүүл мэнд

Группийн хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд бүх ажилтныг урьдчилсан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулж, ажилтанд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнддээ анхаарах боломжийг олгох замаар тогтвортой ажиллах орчныг бүрдүүлэх зорьдог ба тайлант онд урьдчилсан сэргийлэх эрт илрүүлэх үзлэгт нийт 1.5* тэрбум төгрөгийг зарцуулжээ.



*Энержи Ресурс компани ороогүй дүн

▶ Ажилтны санал, санаачилгыг дэмжих

М-Си-Эс Групп ажилтнуудын гаргаж буй шинэ санал, санаачилгыг дэмжиж, дэвшилтэт техник, технологи, инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломжийг ажилтнууддаа олгодог. Үүний хүрээнд бид ажилтны шинэлэг санаа, төслөө бодит бизнес болгоход нь дэмжлэг үзүүлэхээр “Инновацын хөтөлбөр”-ийг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Хөтөлбөрийн хүрээнд бизнесийн процессын шинэчлэл, ажлын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх шинэ санаачилга, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон байгаль орчинд ээлтэй, нийгэмд үр ашигтай шинэ төсөл гэх мэт олон төрлийн санаагаа туршиж, оролцогчтой талуудтай холбож өгөх зэргээр шинэ бизнес

болгох хүртэл нь ажилтнууддаа дэмжлэг үзүүлдэг.

М-Си-Эс Группийн бүх ажилтанд зориулсан үйлчилгээ, урамшууллын талаарх мэдээллийг төвлөрсөн байдлаар авч, бараа бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжийг бүрдүүлсэн “MCS Benefits” платформ, цахилгаан автомашины экосистемийг бий болгохоор цэнэглэгч станц, удирдлагын системийг хэрэгжүүлж буй “EV+” төсөл зэрэг олон шинэ санаачилгыг хөтөлбөрийн хүрээнд бодит ажил болгон нэвтрүүлээд байна.

2023 оны Инновацын хөтөлбөрт нийт дөрвөн төсөл шалгарч, 19 ажилтан өөрсдийн санаагаа бодит ажил болгохоор судалгаа, хөгжүүлэлт, сайжруулалтыг хийж байна.





» Олон янзат байдал ба хүртээмжтэй ажлын байр

● Ажилтан, тэдгээрийн гэр бүлд зориулсан арга хэмжээ

Бид ажилтны эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, хамт олны эерэг, нөхөрсөг харилцааг нэмэгдүүлэх зорилгоор ажилтан болон тэдгээрийн гэр бүл зэрэг зорилтот оролцогч талуудад чиглэсэн спорт, соёл, урлагийн болон чөлөөт арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг. Тухайлбал “MCS Land” арга хэмжээг тайлант онд зохион байгуулж, хүрэлцэн ирсэн ажилтан болон гэр бүлийн гишүүдээс бүрдсэн 20 гаруй мянган зочдод М-Си-Эс Группийн компаниудын талаар, тэдгээрийн тогтвортой хөгжилд чиглэсэн, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй шинэ санал, санаачилга, төслүүдийг танилцуулсан юм. Түүнчлэн сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар, и-спортын тэмцээн болон урлагийн наадам зэрэг ажилтны сайн сайхан байдлыг дэмжих олон арга хэмжээг тогтмол зохион байгуулж ирсэн.





» Сайн дурын үйл ажиллагааг дэмжих

● Ажил олгогчийн дэмжлэгтэй сайн дурын үйл ажиллагаа

Тайлант онд нийгэм болон байгаль орчинд тустай сайн дурын 20 орчим арга хэмжээнд М-Си-Эс Группийн 2,687 ажилтан, 2,440 цагийг мод тарих, хог цэвэрлэх, цус хандивлах, алслагдсан дүүргийн хүүхдүүдэд бэлэг цуглуулан тараах зэрэг сайн дурын үйлсэд ESV хөтөлбөрийн хүрээнд оролцжээ.



Интермед эмнэлгийн ажилтнууд шинэ жилийн баяраар болон олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй хүүхдүүдэд гарын бэлэг бэлтгэн тараасан.

Юнител Группийн 2,100 ажилтан шинэ жилийн баярыг тохиолдуулан 510 орчим бэлгийг цуглуулж, Дорнод, Увс, Говь-Алтай зэрэг алслагдсан аймгийн 1-3 дугаар ангийн сурагч хүүхдүүдэд бэлэглэсэн.

Ажил олгогчийн дэмжлэгтэйгээр сайн дурын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр (ESV) гэж юу вэ?

Ажилтан сайн дурын үндсэн дээр төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй нийгэм, байгаль орчинд тустай сайн дурын үйлсэд оролцож буй ажилтанд нэг өдрийн буюу найман цагийн цалинтай чөлөөг олгодог хөтөлбөр юм.

М банкны хамт олон Үндэсний дээд лигийн М Гарьд багтай хамтран сагсан бөмбөгийн спортоор хичээллэх өдөрлөгийг Сонгинохайрхан дүүргийн 42, 162, 105, 149 дүгээр сургуулиудад зохион байгуулж, 80 орчим сурагчийг хамруулсан юм.



2023 онд Шангри-Ла Улаанбаатар компанийн ажилтнууд Тэрэлж орчмын болон 143 дугаар цэцэрлэгийн хашаан дахь хог хаягдлыг цэвэрлэсэн бол Юнител Группийн ажилтнууд Туул голын сав газрын хамгаалалтын захиргаатай хамтран Туул голын сав газрыг сайн дурын ажилтнуудын хамтаар цэвэрлэсэн юм. Түүнчлэн Анунгоо компанийн ажилтнууд Туул голын ундны эх үүсвэр орчмын газрыг цэвэрлэх ажилд оролцжээ.



» Сургалт хөгжил ба чадавх бэхжүүлэх

1,441

Нийт сургалтын тоо

362 М-Си-Эс Академийн сургалт

568 Компани доторх сургалт

511 Бусад сургалт

14,311

Ажилтан сургалтад хамрагдсан

5,981 Сургалтад хамрагдсан эмэгтэй ажилтны тоо

3.4 тэрбум

Сургалтын нийт зардал

► М-Си-Эс Академи

Хамтдаа тасралтгүй хөгжих, мэдлэг, мэдээллээ бусадтайгаа хуваалцах зарчимд тулгуурлан ажилтнууд бие биеэ хөгжүүлэх боломжийг олгодог М-Си-Эс Академи нь 70 гаруй дотоодын сургагч багш, 100 гаруй сэдвээр ерөнхий болон мэргэжлийн ур чадвар, Группийн ажилтны суурь чадамжийг хөгжүүлэх сургалт, хөтөлбөрийг тогтмол зохион байгуулдаг.

6,990

ажилтан М-Си-Эс Академийн сургалтад хамрагдсан

46%
эмэгтэй

1,757

Нийт сургалтын цаг



М-Си-Эс Академи 2023 онд шинээр 20 сургалтыг нэвтрүүлснээс бүрэн онлайн есөн сургалтыг орж эхэлсэн бөгөөд өмнө танхимаар ордог байсан дөрвөн хичээлийг цахим болгон шинэчилсэн юм. Бүрэн цахим сургалтуудыг санал болгож эхэлснээр хүн бүр өөрийн суралцах хурддаа тохируулан, өөрт тохиромжтой үедээ сургалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлж байгаа юм.

Мөн 2023 оноос ажилтны сайн сайхан байдлыг дэмжих зорилгоор сэтгэлийн амар амгалан, ажил, амьдралын хэв маяг, өөрчлөлтөд дасан зохицох, хувийн санхүүгээ удирдах зэрэг зургаан сэдвээр сургалтын агуулгыг боловсруулан ажилтнууддаа хүргэж эхлээд байна.



» Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй

М-Си-Эс Групп нь бүх ажилтан, туслан гүйцэтгэгчийн эрүүл, аюулгүй ажиллагааг ханган ажиллахыг зорьдог бөгөөд аюулгүй ажиллагааны дүрэм журмыг боловсруулах, үйл ажиллагааг системчлэх, аюулгүй ажиллагааны соёлыг бэхжүүлэх, олон улсын туршлагыг нэвтрүүлэх зэрэг сайжруулалтыг тасралтгүй хийсээр байна.

Үзүүлэлт	2022	2023
ХАБЭА сургалт, зааварчилгаанд хамрагдсан ажилтны тоо	47,727	92,949
ХАБЭА сургалтад зарцуулсан нийт дүн (төгрөгөөр)	279 сая	354 сая
Хөдөлмөрийн чадвар түр алдсан ослын давтамж буюу LTIFR	0.21	0.11
100 ажилтанд ногдох ослын хүндрэлийн зэрэг буюу SR	3.08	2.98
Бууруулсан эрсдэлийн хэмжээ		79%

► Галын аюулгүй байдал

М-Си-Эс Групп эрсдэлийн менежментийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу галын аюулгүй байдлын үзлэгийг тогтмол хийж, нийт ажилтнууддаа урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах сургалт, сургуулилыг тогтмол хийдэг.

Тайлант онд 23 компанийн 32 барилга, байгууламжид галын үзлэгийг хийж гүйцэтгэсэн ба дундаж оноо 83 хувь болж, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хүрээнд илэрсэн зөрчлийг бууруулах арга хэмжээг авч байна.

Галын аюулгүй байдал	2022	2023
Компани	17	23
Барилга, байгууламж	21	32
Илэрсэн зөрчил	195	223
Дундаж оноо	73%	83%



» Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

● Соёлын өв

М-Си-Эс Групп “Өв Эрдэнэ” хөтөлбөрийн хүрээнд үндэсний өв соёл, үнэт зүйлсийн бэлгэ тэмдэг болсон түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалах, хойч үедээ өвлүүлэх зорилготойгоор өнгөрсөн таван жилийн хугацаанд Монголын Урлагийн зөвлөл ТББ-тай хамтран ажиллаж, Монгол Улсын Соёлын Яам, Соёлын өвийн үндэсний төв болон дотоод, гадаадын дурсгалт барилгын сэргээн засварлалтын зөвлөх, экспертүүдийн дэмжлэгтэйгээр Чойжин ламын сүм музей, Богд хааны ордон музей, Занабазарын музей, Амарбаясгалант хийд тэргүүтэй нийт 15 төсөлд 2.5 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгосон юм.



Тайлант онд Хэнтий аймагт байрлах Сэцэн Ханы Ордон музейн гадна талбайн зүлэгжүүлэлт, ногоон байгууламж, соёлын дурсгалт уран барилгын хадгалалт, хамгаалалт, гэрэлтүүлэг зэрэг орчны тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн олон нийтийн чөлөөт цагаа өнгөрүүлэх талбайг тохижууллаа.


Түүнчлэн Морин хуурын чуулгын “Монгол Аялгуу” хос пьанз төслийг дэмжин ажилласнаас гадна Чойжин ламын сум музейн ногоон байгууламжийн арчилгаа, үйлчилгээг санхүүжүүлэн тохижууллаа.





» Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

• Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж



Анунгоо компани “Охидын эрүүл мэндийн боловсрол олгох” сургалтыг Нийслэлийн боловсролын газар, Интермед эмнэлэг болон ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран 6, 7 дугаар ангийн сурагчдыг арваннэгдүгээр сараас сургалтад хамруулсан байна.

Вэллбий компани эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор амин дэм ба дархлаа сэргээх бэлдмэлийг эрүүл мэндийн байгууллагуудад үнэ төлбөргүй хандивладаг. Тус компани 2023 онд Улаанбаатар хотын хоёр болон орон нутгийн найман эмнэлэгт 4,000 орчим эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг хандивлажээ.

Интермед эмнэлэг Кристина Ноблийн Хүүхдийн сангийн дэргэдэх Нархан асрамж халамжийн төвийн 50 хүүхдийг үнэ төлбөргүй эмчийн үзлэгт хамруулж, томуугийн эсрэг дархлаажуулалтын вакцинд хамрууллаа.



Энержи Ресурс компани “Орон нутгийн эрүүл мэндийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд ЭХЭМҮТ-ийн хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарыг Цогтцэций суманд урьж, сургуулийн болон сургуулийн өмнөх насны 900 гаруй хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоонд үнэ төлбөргүйгээр хамрууллаа.




» Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

● Хүртээмжтэй боловсрол

Их, дээд сургуулийн оюутан залууст ажлын гараагаа зөв, системтэй эхлүүлж, ажлын бодит туршлага хуримтлуулангаа өөрийгөө хөгжүүлэх, салбар бүрийн шилдэг мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж бизнесийн байгууллагын соёлд суралцах боломжийг олгодог “MCS Internship” цалинтай дадлагажих хөтөлбөрт 80 оюутныг хамрууллаа.



Ховордсон сурах бичгийн хүртээмжийг нэмэгдүүлж, багш эрдэмтдийн бүтээлийг боловсролын үнэт өв соёл болгон хадгалах, багш оюутнууд зайнаас ажиллаж суралцах боломжийг нэмэгдүүлэх зорилготой “Нээлттэй сурах бичиг” төслийг М-Си-Эс Кока-Кола болон Юнител компаниуд, M book платформтой хамтран байгалийн ухааны салбарын эрдэмтэн, багш нарын 20 гаруй сурах бичиг, ном бүтээлүүдийг цахим хэлбэрт хөрвүүлэн хүссэн хүн бүр үнэ төлбөргүй ашиглах боломжийг бүрдүүлсэн юм.



Интермед эмнэлэг ирээдүйн чадварлаг эмч мэргэжилтнийг бэлтгэхэд хувь нэмрээ оруулахаар Этүгэн их сургуультай хамтран ажиллаж, сувилахуйн мэргэжлийн 36 оюутныг дадлагажуулах хөтөлбөрт хамруулан ажлын туршлага хуримтлуулах, зөөлөн ур чадвараа хөгжүүлэх, мэргэжлийн мэдлэгээ бататгах боломжийг олголоо.





» Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

● Хүртээмжтэй боловсрол

Тотал Дистрибьюшин компани жил бүр өөрийн ойн өдрөө тохиолдуулан сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуусын унших, бичих, илтгэх ур чадварыг сайжруулж, өөрийгөө илэрхийлэх боломжийг олгох, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Миний мөрөөдөл” эсээ бичлэгийн уралдааныг Монголын сонсголгүй иргэдийн “Диф” клубтэй хамтран зохион байгуулдаг уламжлалтай бөгөөд 2023 онд нийслэлийн болон орон нутгийн 41 хүүхэд, залуус оролцсон байна.



Энержи ресурс компани “Орон нутгийн боловсролыг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд сурагч хүүхдүүдэд хичээлээс гадуурх нэмэлт хөтөлбөр олгох, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, сурлагын хоцрогдол арилгахад нь дэмжлэг үзүүлэх “Мөрөөдлийн хөтөч” сургалт, хөгжлийн төвийг уурхайчдын “Цэций” хороололд тусгайлан байгууллаа. Нийт 200 орчим хүүхэд хамруулах хүчин чадалтай энэхүү сургалтын төвд 4-12 дугаар ангийн сурагчдад Математик, Англи хэл, Хятад хэл, EQ болон програмчлалын мэдлэг олгох нэмэлт сургалтуудыг хүргэж байна.



Мөн “Цалинтай оюутан” зуны хөтөлбөрт Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо, Хаянхонгор сумын харьяат 33 оюутан хамрагдаж, хоёр сарын хугацаанд Ухаа худаг уурхайд түр хугацааны туслах ажилтнаар цалинтай ажиллангаа ажлын бодит туршлага хуримтлууллаа.



» Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

● Цаг үеийн хандив, тусламж

Нийслэл хотод үргэлжлэн орсон борооны улмаас үерийн нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан үерийн бүсэд ажиллаж байгаа албан хаагчдад М-Си-Эс Кока-Кола, Юнител Групп, М-Си-Эс Проперти компаниуд 30 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалын болон мөнгөн тусламжийг хүлээлгэн өглөө.



▶ Нийгэм, жендерийн оролцоог хангах

М-Си-Эс Проперти компани хэрэгжүүлж буй “Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн төсөл”-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд төслийн шууд нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдэд өөрсдийн арга хэмжээ болон ажлын явцыг танилцууллаа. Түүнчлэн тухайн бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг эмэгтэй эзэмшигчтэй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөлтэй уулзан төслийн үр шимийг тэгш хүртээхэд чиглэсэн, зорилтот уулзалтыг зохион байгуулсан юм.

▶ Дижитал шилжилт, хүртээмжийг бий болгох

Юнител Групп орон нутагт мэдээллийн технологийн хүртээмжийг нэмэгдүүлж, хөдөө, орон нутгийн цахим боловсролын ялгааг багасгах зорилгоор Unitel HUB хөтөлбөрийг 2022 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Тайлант онд 11 аймагт Unitel HUB төвийг шинээр байгуулсан ба энэхүү төвүүддээ НҮБ-ийн Хүн амын сан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Women in Tech хөтөлбөр зэрэг оролцогч талуудтай хамтран сургалтыг орохоос гадна бие даан суралцах боломжтой сургалтын цогц материал, өндөр хурдны интернэттэй суурин компьютер бүхий сургалтын тав тухтай орчныг бүрдүүлсэн юм.

Түүнчлэн хүүхэд багачуудад шинжлэх ухаан, инженерчлэл, математик болон технологийн салбарын мэдлэг олгож, сонирхлыг нь дэмжих зорилгоор 8-14 насны хүүхдүүдэд электроник болон роботикийн талаар анхан шатны боловсрол олгох 30 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 323 сурагчийг хамруулжээ.





» Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

● Орон нутгийн иргэдэд чиглэсэн арга хэмжээ

Энержи Ресурс компани нийгэм, орон нутагт чиглэсэн, урт хугацааны үр өгөөжтэй төсөл, хөтөлбөрүүдийг оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлж ирсэн ба 2023 онд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөрт нийт 25.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, хандив тусламжийг олгосон байна.

▶ Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих

Орон нутгийн малчид, иргэдийн жижиг, дунд бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор Хас банктай хамтран хэрэгжүүлдэг “Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 13 иргэнд 140 сая төгрөгийн хүүгүй зээлийг олгосон. Түүнчлэн Цогтцэций сумын 200 орчим ЖДҮ эрхлэгчийг хамруулсан

▶ Сайн хөрш хөтөлбөр

Энержи Ресурс компани Цогтцэций сумын иргэдийг цахилгаан болон ундны цэвэр усаар тогтмол хангахаас гадна Даланзадгад сумын цахилгаан станц, Өмнөговь аймгийн 11 сумдад 36 мянга орчим тонн дулааны нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлдэг. Мөн нөлөөллийн бүсийн 430 малчинд болон Цогтцэций, Цогт-Овоо сумын фондод нийт 9,000 боодол өвс, 45 тонн тэжээлийг хандивласнаас гадна Цогтцэций суманд байрлах зорилтот бүлгийн 140 гаруй ахмад настнуудад хүнсний багцыг тусламжаар хүргэлээ.



▶ Газар тариалан эрхлэлтийг дэмжих

Энержи Ресурс компани Ойн зурвасын найман га талбайг Цогтцэций сумын иргэдийн газар тариалан эрхлэх идэвх, санаачилгыг нь дэмжих, туршлага ур чадварыг нь нэмэгдүүлэх, цаашлаад өрхийн бизнесийг нь чадавхжуулах зорилгоор ашиглуулдаг. 2023 онд шинээр Цогтцэций сумын 15 өрх, нэг албан байгууллага 20 төрлийн хүнсний ногоог талбайд тарьж эхэлсэн. Мөн жил бүр зохион байгуулдаг ургацын баярт энэ жил 100 гаруй өрх оролцлоо.

25.3 тэрбум

төгрөгийг Энержи Ресурс компани хөрөнгө оруулалт, хандив тусламж хэлбэрээр олгожээ



» Олон нийт, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

● Орон нутгийн иргэдэд чиглэсэн арга хэмжээ

Мэтагро компани Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг Чандганы талд газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хосолсон хөдөө аж ахуйн иж бүрэн цогцолборыг байгуулж, 200 гаруй ажлын байрыг шинээр бий болгосноос 60 гаруй нь орон нутгаас, тэр дундаа Хэнтий аймгаас ирж ажиллаж байна. Түүнчлэн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, ажиллах хүчний нөөц бүрдүүлэн орон нутгийн, нийгмийн асуудлуудыг шийдвэр зорилгоор ажлын байрны өдөрлөгийг Хэнтий аймагт 2023 онд зохион байгуулсан.



Мэтагро компани орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, бэлчээрт өссөн бага залуу үхрийг малчдаас тогтмол худалдан авч, бүс нутгийн малчдад жилийн дөрвөн улиралд орлого олох боломжийг бүрдүүлээд байна.

Мөн Монголын тариаланчдын үндэсний холбоо, Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газраас хамтран зохион байгуулсан “Зүүн бүсийн тариаланчдын зөвлөгөөн”-ийг Мэтагро компани дэмжин ажиллаж, зөвлөгөөнийг Чандгана талд байрлах Гардэн Кэмп ажилчдын хотхонд зохион байгууллаа.

Тус зөвлөгөөнд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын тариаланчид, ХХААХҮЯ, ХААИС-ийн ажилтнууд, эрдэмтэн доктор зэрэг нийт 90 гаруй төлөөлөгч оролцож газар тариалангийн талаар төр, засгаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд, цаашдын зорилт чиглэлийн талаар мэдээлэл хийн орон нутгийн тариаланчид, малчин иргэдтэй хамтран ажиллах боломж нээгдэж байгааг дурдсан юм.



Засаглал »



» Засаглалын бүтэц

- М-Си-Эс Групп нь засаглалын цогц тогтолцооныхоо хүрээнд үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн зорилго, ойлголтуудыг тусган хэрэгжүүлж, оролцогч талууддаа урт хугацааны үр ашгийг бий болгохоор ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилдог бөгөөд бизнесийн болон санхүүгийн салбарт ажиллаж байсан туршлагатай, олон талын ур чадвар бүхий гишүүдээс бүрддэг.

ТУЗ-ийн дэргэдэх БОНЗ-ын хороо нь тогтвортой хөгжил болон БОНЗ-ын тогтолцоотой уялдсан бизнесийн бодлого, урт хугацааны стратегийг тодорхойлж, хяналт тавих үүрэгтэйгээр ажилладаг.

Харин М-Си-Эс Холдинг компани нь дээрх чиглэлийн хүрээнд БОНЗ-ын тогтолцоог Группийн хэмжээнд нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах, тайлагнах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөл





» Эрсдэлийн менежмент

- М-Си-Эс Группийн охин болон хөрөнгө оруулалттай компаниуд өөрсдийн үйл ажиллагаандаа эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тогтмол хянадаг.



М-Си-Эс Группийн компани бүр эрсдэлийн менежмент хариуцагч ажилтныг томилон ажиллуулдаг бөгөөд улирал бүр тогтмол уулзалт зохион байгуулж, эрсдэлийг удирдаж буй сайн туршлагаасаа хуваалцдаг.

М-Си-Эс Группийн Эрсдэлийн менежментийн журмыг тайлант онд **ISO 31000:2018** стандарттай уялдуулан шинэчлэн баталсан.

Энэхүү журамд:

- Эрсдэлийн менежментийн тогтолцоо
- Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ
- Эрсдэлийн ангилал
- Эрсдэлийн менежментийн ажлын урсгал болон үүрэг хариуцлага
- Баримт бичгийн жишиг загвар зэргийг тодорхойлсон байдаг.

Түүнчлэн Аудит ба эрсдэлийн хорооны дүрмийг тайлант онд баталлаа. Дүрэмд М-Си-Эс Холдинг компани дээрх Аудит ба эрсдэлийн хороо, түүний бүтэц, эрх, үүрэг, үйл ажиллагаа, хурлын зохион байгуулалт, хурлын шийдвэр гаргалтыг тодорхойлсон юм.



» Тогтвортой нийлүүлэлтийн гинжин хэлхээ ба худалдан авалт



М-Си-Эс Групп нь аливаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжин бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нь худалдан авахыг эрмэлздэг. Үүний хүрээнд бид нийлүүлэгчдэдээ өрсөлдөөний тэгш боломжийг хангах зорилгоор худалдан авалтын урилгыг албан ёсны сувгаар нээлттэй зарлаж, хамтран ажиллах хүсэлтэй шинэ нийлүүлэгчдийг байнга татан оролцуулдаг.

Түүнчлэн М-Си-Эс Группийн үнэт зүйлсийг нийлүүлэлтийн гинжин хэлхээгээр дамжуулан түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн нийлүүлэгч бүрийн дагаж мөрдөх **Нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм** -ийг хамтран ажилладаг нийлүүлэгчдэдээ, тэдгээрийн ажиллагсад, төлөөлөгч, харилцан холбоо хамаарал бүхий хуулийн этгээд болон туслан гүйцэтгэгчдэд тайлбарлан таниулж, мөрдүүлэн ажилладаг.

► М-Си-Эс Группийн худалдан авалтын арга:

Худалдан авах ажиллагааг нээлттэй, шударга, зах зээлийн өрсөлдөөнт үнэд суурилсан, үр ашигтай, хариуцлагатай байх зарчим баримтлан гүйцэтгэдэг. Худалдан авалтын нэгж босго үнээс хамааруулан:

300 сая төгрөг хүртэлх

хүртэлх худалдан авалтыг гурваас доошгүй Нийлүүлэгчээс санал авч харьцуулсны үндсэн дээр шалгаруулна.

300 сая төгрөгөөс дээш

дээш худалдан авалтыг Тендер шалгаруулалтын аргаар шалгаруулна.

Худалдан авалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим

- ☑ Монгол Улсад хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж болон зохих эрх зүйн хэм хэмжээг чанд мөрдөх;
- ☑ Хүний эрхийг дээдэлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах;
- ☑ Нийлүүлэгчдийг тэгш өрсөлдөх боломжоор хангах;



Тогтвортой нийлүүлэлтийн гинжин хэлхээ ба худалдан авалт

Нийлүүлэгчийн портал

М-Си-Эс Групп Нийлүүлэгч байгууллагууддаа худалдан авах үйл явцыг улам хялбарчилж, хамтран ажиллах хүсэлтэй дотоодын бүх бизнес эрхлэгчид мэдээллийг ил тод, хүртээмжтэй хүргэж, байгууллага, хувь хүн бүрт нийлүүлэгчээр оролцох боломжийг бүрдүүлэн хамтран ажиллах явцыг хөнгөвчлөх зорилгоор олон улсын жишигт нийцсэн худалдан авалтын цогц системийг 2023 онд нэвтрүүллээ.

Нийлүүлэгчийн портал нь Группийн идэвхтэй худалдан авалтын мэдээллийг нэг дороос харах, худалдан авалтад бүртгүүлэх, үнийн санал илгээх, шалгаруулалтын үйл явцыг хянах, тодруулга авах зэрэг худалдан авалтад оролцох, нийлүүлэгчээр шалгарах бүх үе шатыг нэг дороос хянах боломжтой цогц, ил тод систем юм.

Түүнчлэн худалдан авалтын шинэ зарын мэдээллийг нийтлэгдсэн даруйд нь хүлээн авч, баримт бичгээ цахимаар бүрдүүлэн үнийн саналыг илгээх боломжийг олгосноор худалдан авалтад оролцох үйл явцыг хөнгөвчилж байна.

▶ 2023 оны байдлаар Нийлүүлэгчийн порталд:

2,400

Бүртгэлтэй нийлүүлэгч

680


Худалдан авалтын зар

90

Тендер шалгаруулалт

590

Үнийн санал





Эдийн засагт оруулж буй хувь нэмэр

М-Си-Эс Группийн охин болон хөрөнгө оруулалттай компаниуд 2023 онд

966 тэрбум

төгрөгийн татвар, шимтгэлийг улсын төсөвт оруулсан.

987 тэрбум

төгрөгийн хөрөнгө оруулалтыг Монгол Улсын эдийн засагт хийсэн



13 мянган

ажилтандаа сард 43 тэрбум төгрөгийн цалин, урамшууллыг олгосон

20,000+

шууд бус ажлын байрыг бий болгосон

3.5 их наяд

төгрөгийн худалдан авалт хийснээс

2.2 их наяд

төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг

8,600

дотоодын компани болон хувь хүнээс худалдан авсан

50 тэрбум

төгрөгийг нийгмийн хариуцлагын 45 төсөл, хөтөлбөрт зарцуулсан

38 тэрбум

төгрөгийн баяжуулсан эрчим хүчний нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлсэн



Товчилсон үгийн жагсаалт

Нэгжийн тайлбар

БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
GRI	Тайлагналын олон улсын санаачилга
SASB	Тогтвортой байдлын нягтлан болох бүртгэлийн стандартын зөвлөл
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
PET	Полиэтилен терефталат
HDPE	Өндөр нягтралтай полиэтилен
LDPE	Бага нягтралтай полиэтилен
PP	Полипропилен
ТББ	Төрийн бус байгууллага
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль

МВт.ц	Мегаватт цаг
CO2	Нүүрстөрөгчийн давхар исэл
МЖ	Мегажоуль
КВт.ц	Киловатт цаг
м3	Шоо метр
га	Арван мянган хавтгай дөрвөлжин метр
м2	Хавтгай дөрвөлжин метр
кг	Килограмм



Дэлхийн хөгжлийг Монголд